



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/154

Мандалговь


Инженерийн хийцтэй худаг шинээр
барьж байгуулах- Багц 3 ажлын
гэрээг хүчингүй болгох тухай

2020 он 6 дугаар сарын 8-ны өдрийн байгуулсан “Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах” ДУГАОНӨГ/202003038 дугаартай гэрээний ерөнхий нөхцөлийн 17.1, “Топ дриллинг” ХХК-ийн 2020 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах” багц-3 ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Топ дриллинг” ХХК-тай байгуулсан 193,065,309 (нэг зуун ерэн гурван сая жаран таван мянга гурван зуун ес) төгрөгийн гэрээ болон 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн А/114 дүгээр гэрээ байгуулах тухай тушаалыг хүчингүй болгосугай.

Хоёр. “Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах” багц-3 ажлын гүйцэтгэгчийг дахин шалгаруулан зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын даргыг түр орлон гүйцэтгэгч (М.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060658